

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ГАЗРЫН
2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТАЙЛАНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ДҮН**

2026.06.23

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний холбогдох стратегийн зорилгуудын хүрээний 14 зорилтын 35 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Тус газрын гүйцэтгэлийн тайланг "Журам батлах тухай" Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 2.4, 2.5-т заасан аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хүрэх түвшин нь 01-12 сар (жилийн) болж заасан арга хэмжээг хагас жилийн байдлаар үнэлэхдээ зорилтот түвшинг 50%-иар хуваан авч, гүйцэтгэлтэй харьцуулан тооцлоо.

Гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ холбогдох аргачлалын дагуу батлагдсан төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг тус тус харгалзан үзсэн.

Хүснэгт-1

№	Төлөвлөлтийн хэсэг	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувь /өөрсдийн үнэлсэн/	ХШУДАГ-аас өгсөн үнэлгээ
1	Зорилт 1. Төрийн албаны шинэчлэлийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээний журмыг шинэчлэх	1	2	70%	60%
2	Зорилт 2. Төрийн чиг үүргийн давхардлыг арилгах, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулахын тулд төрийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, дахин инженерчлэлийн ажлыг эрчимжүүлэх	1	1	50%	50%
3	Зорилт 3. Төрийн болон бүх шатны захиргааны байгууллагын нийтлэг чиг үүрэг хэрэгжүүлдэг нэгжид чиг үүргийн шинжилгээ хийж, бүтэц, орон тоог оновчтой тогтоох санал, дүгнэлт боловсруулж танилцуулах	1	2	100%	100%
4	Зорилт 4. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	1	6	73%	73%
5	Зорилт 5. "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн цахим систем"-ийг	1	2	95%	95%

	хөгжүүлж, төрийн байгууллагуудад үе шаттай нэвтрүүлэх				
6	Зорилт 6. Төрийн бүтээмжийн нэгдсэн мэдээллийн систем хөгжүүлэх ажлын хүрээний Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих системийг үргэжлүүлэн хөгжүүлж, Төрийн албаны сургалтын нэгдсэн системийг хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлэх	1	3	90%	90%
7	Зорилт 7. Төрийн албаны сургалтын чанарыг дээшлүүлэх	1	2	90%	85%
8	Зорилт 8. Төрийн албаны эрх зүйн орчин, хүний нөөцийн болон төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн асуудал, ЗГ-аас томилж, чөлөөлөх албан тушаалтны томилгооны шийдвэрийн төслийг боловсруулан, ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлэх	1	3	100%	100%
9	Зорилт 9. Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ЗГ-ын байгууллагуудын хүрээнд зохион байгуулж, удирдлага зохицуулалтаар хангах	1	7	83%	81%
10	Зорилт 10. Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх ажлын шийдвэр гаргалтад бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	1	2	85%	85%
11	Зорилт 11. ЗГ-ын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүдийг уялдаа, удирдлага зохицуулалтаар хангаж, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	1	1	100%	100%
12	Зорилт 12. Монгол Улсын Ерөнхийлөгч нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдээр төрийн дээд цол, одон, медалиар шагнах асуудлыг судалж шийдвэрлэх, шагнал гардуулах ёслолын ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	1	2	100%	100%
13	Зорилт 13. Байгууллага, нэгжүүд, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, "Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн цахим систем"-д оруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах	1	1	100%	100%
14	Зорилт 14. Иргэн, хуулийн этгээд, төрийн бусад байгууллагаас Ерөнхий сайд, ЗГХЭГ-ын удирдлагад хандаж ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, хуульд заасан хугацаанд хариу өгч, шийдвэрлэх	1	1	100%	100%

Дундаж ерөнхий үнэлгээ	14	33	88.3%	87.1%
------------------------	----	----	-------	-------

Хүснэгт-2

Газар, хэлтэс	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	85 буюу түүнээс дээш хувь бол "бүрэн хангалттай" (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшинд нь хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд нь бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн)	70-85 хүртэл хувь бол "хангалттай" (шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд нь бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах)	70 хүртэл хувь бол "хангалтгүй" (удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй нь баримтаар нотолгоотой.)
ЗГХНГ	14	33	10	2	2

ДҮГНЭЛТ

Засгийн газрын хүний нөөцийн газраас 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг **88.3%** хувиар үнэлж ирүүлснийг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж **87.1%** хувиар үнэлэв.

↙ Үнэлгээг хамарсан 14 зорилтоос "бүрэн хангалттай" (≥85%) — 10 зорилт, "хангалттай" (70-85%) — 2 зорилт, "хангалтгүй" (<70%) — 2 зорилт тус тус авсан.

Засгийн газрын хүний нөөцийн газрын 2026 оны эхний хагас жилд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлаас онцолбол:

- Нийт 636 байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, Засгийн газрын 119, 165 тогтоол болон 25 дугаар тэмдэглэлийг гаргуулан яамдын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн сайжруулах санал, зөвлөмжийг тус тус боловсруулан Засгийн газрын хуралдаанд 2026.04.08 болон 2026.05.13-нд танилцуулсан.
- 435 байгууллага, 22,211 албан хаагчийн мэдээллийг гүйцэтгэлийн удирдлагын цахим системд нэвтрүүлсэн.
- ЗГХЭГ-т цахим системийн нэвтрүүлэлт 100%, 11 нэгж, 119 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө цахим системаар 100% батлагдсан.
- Засгийн газраас томилогдох албан тушаалтнуудтай холбоотой нийт 71 тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулж, 67 шийдвэр батлагдсан (ЗГ-ын тогтоол 29, тэмдэглэл 8, Ерөнхий сайдын захирамж 30).
- Төрийн албаны тухай хуулийн шинэчлэлийн ажлын хэсгийг ЗГХЭГ-ын даргын 51 тушаалаар байгуулж, 4 дэд ажлын хэсгийг 378 тушаалаар байгуулан ажлыг эхлүүлсэн.

Засгийн газрын хүний нөөцийн газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс анхаарах шаардлагатай ажлаас дурдвал:

- Зорилт 1 (70%): Байгууллагын болон албан хаагчийн гүйцэтгэлийн журмыг шинэчлэх (батлуулах) ажлыг хоёрдугаар хагас жилд эрчимжүүлэх шаардлагатай.

- Зорилт 2 (50%): Төрийн байгууллагуудын дахин инженерчлэлийн ажлыг үргэлжлүүлэн, хоёрдугаар хагас жилд үйл ажиллагааны дүн шинжилгээг дуусгах.
- Зорилт 9.5 (60%), 9.6 (60%): Жендэрийн болон олон улсын хамтын ажиллагааны арга хэмжээний тоог зорилтот түвшинд хүргэх.

ЗӨВЛӨМЖ

- Байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн журмыг шинэчлэх Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, хоёрдугаар хагас жилд Засгийн газрын хуралдаанаар батлуулах;
- Гүйцэтгэлийн удирдлагын цахим системийн тайлангийн модуль болон үнэлгээний модулийн хөгжүүлэлтийг эрчимжүүлж, 2026 онд нэвтрүүлэх зорилтыг хэрэгжүүлэх;
- Засгийн газрын 127 дугаар тогтоолын хүрээний ЗГХНГ-ын мэдээллийн систем хөгжүүлэлтийн асуудлыг тодорхойлж, цаашдын чиглэлийг удирдлагаас авах;
- Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт, зөвлөмжийн дагуу зорилтот түвшинд хүрээгүй арга хэмжээг үлдсэн хагас жилийн хугацаанд эрчимжүүлэн ажиллах.

ХЯНАСАН:



ДЭД ДАРГА С.БАТБОЛД

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:



ЗАСГИЙН ГАЗРЫН РЕФЕРЕНТ
Б.ОРГИЛ

Хавсралт

Хүснэгт-3

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ГАЗРЫН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮН
/ЗААЛТ БҮРИЙН ҮНЭЛГЭЭ/**

Арга хэмжээний д/д	Арга хэмжээний дугаар	Өөрсдийн өгсөн үнэлгээ	ХШҮ хийсэн үнэлгээ	Үнэлгээний тайлбар
Зорилт 1. Төрийн албаны шинэчлэлийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээний журмыг шинэчлэх				
1	1.1	70	70	Журмын нэмэлт, өөрчлөлтийн ЗГ тогтоолын төсөл, танилцуулга боловсруулсан. ЗГ-ын 2026.01.14-ний хуралдаанд танилцуулга оруулсан. Цахим системийн хөгжүүлэлтэд бодлогын даалгавар өгч ажиллаж байна. Хагас жилийн зорилтот 1 (дүн шинжилгээний танилцуулга)-ийг гүйцэтгэсэн. Журам батлагдаагүй (1.2) тул дундаж 70%.
2	1.2	70	50	Журам, аргачлалыг шинэчлэх ЗГ тогтоолын төслийн эхний хувилбарыг боловсруулж удирдлагад танилцуулсан. Хагас жилийн зорилтот 1 журам батлуулах шаардлагатай боловч батлагдаагүй.
Зорилт 2. Төрийн чиг үүргийн давхардлыг арилгах, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулахын тулд төрийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, дахин инженерчлэлийн ажлыг эрчимжүүлэх				
3	2.1	50	50	Хагас жилийн зорилтот 3 үйлчилгээний оронд 2026 оны 02 сарын 13, 03 сарын 18, 25-нд хэлэлцүүлэг зохион байгуулсан. Гэвч сонгогдсон үйлчилгээний тоо 3-аас дутуу.
Зорилт 3. Төрийн болон бүх шатны захиргааны байгууллагын нийтлэг чиг үүрэг хэрэгжүүлдэг нэгжид чиг үүргийн шинжилгээ хийж, бүтэц, орон тоог оновчтой тогтоох санал, дүгнэлт боловсруулж танилцуулах				
4	3.1	100	100	Нийт 636 байгууллагад чиг үүргийн шинжилгээ хийж, дүн шинжилгээг ЗГХЭГ-ын даргад 2026.03.11, ЗГ-ын хуралдаанд 2026.04.08 танилцуулсан. 15 яаманд үндсэн чиг үүргийн шинжилгээ хийж 2026.05.13-ны хуралдаанд танилцуулсан. 34 агентлаг болон 72 улсын төсөвт үйлдвэрийн газарт шинжилгээ хийсэн.
5	3.2	100	100	ЗГ-ын тогтоол /119/, тэмдэглэл /25/ зэрэг шийдвэрүүдийг гаргуулсан. Боловсролын яамны бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг 2026.04.29-ний 165 дугаар тогтоолоор батлуулсан. 4 байгууллагын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хянасан.
Зорилт 4. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх				

6	4.1	90	90	Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ, SWOT шинжилгээ, хуулийн эхний хувилбар боловсруулсан. Армени улсын аттестатчилалтай холбоотой бүлгийг боловсруулсан. 4 чиглэлийн 60 гаруй асуудлыг тодорхойлж санал, шийдлийг танилцуулсан. Хагас жилийн зорилтот 3 судалгааны 3-ыг гүйцэтгэсэн
7	4.2	90	90	41 журам, дүрэм, жагсаалт, аргачлалыг нэгтгэн шинжилгээ хийсэн. Хагас жилийн зорилтот 3-аас гүйцэтгэл хэвийн.
8	4.3	90	90	Хүчингүй болгох, шинэчлэх журмын жагсаалт гаргасан. Сахилгын шийтгэлийн журам болон Шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журмыг Төрийн албаны зөвлөлтэй хамтран боловсруулсан. Чиг үүргийн шинжилгээний журам, аргачлалын төслийн бүтцийг боловсруулж байна. Журмын зөвшөөрлийн ЗГ-ын тогтоолыг 2026.06.17 батлуулсан.
9	4.4	40	40	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.3.4-ын хүрээний танилцуулгыг боловсруулж удирдлагад хүргүүлсэн. Гэвч хагас жилийн зорилтот 1 дүн шинжилгээний танилцуулга гүйцэтгэл доогуур.
10	4.5	40	40	Гадаад улс орнуудын туршлагыг судалж дэд даргад хүргүүлсэн. Гэвч хагас жилийн зорилтот 2 улсаас 40%-ийн гүйцэтгэлтэй.
11	4.6	90	90	ЗГХЭГ-ын даргын 51 тушаалаар Ажлын хэсэг байгуулагдаж, 06.05-нд анхдугаар хуралдааныг зохион байгуулсан. 4 дэд ажлын хэсгийг 378 дугаар тушаалаар байгуулсан. ТАЗ-ын дарга, яамдын ТНБД, ЕС-ын зөвлөхүүдтэй уулзалт хийж, хуулийн шинэчлэлийн замын зураглалыг хэлэлцсэн.
Зорилт 5. "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн цахим систем"-ийг хөгжүүлж, төрийн байгууллагуудад үе шаттай нэвтрүүлэх				
12	5.1	100	100	15 байгуулагад туршилтаар нэвтрүүлж, 1359 (нийт 1670-аас) албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө системд батлуулсан. Гүйцэтгэлийн төлөвлөлтийн модулийн хөгжүүлэлт 100% дуусгасан. Жилийн зорилтот 15-ийн 50% болох 7.5-аас 15 нь их .
13	5.2	90	90	435 байгуулага, 22,211 албан хаагчийг системд бүртгэж нэвтрүүлсэн. Жилийн зорилтот 600-ийн 50% болох 300-аас 435 нь их. Тайлангийн модуль 95%, үнэлгээний модуль 90%+ хувийн хөгжүүлэлттэй байна.
Зорилт 6. Төрийн бүтээмжийн нэгдсэн мэдээллийн систем хөгжүүлэх ажлын хүрээний Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих системийг үргэлжлүүлэн хөгжүүлж, Төрийн албаны сургалтын нэгдсэн системийг хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлэх				

14	6.1	0	Үнэлэх боломжгүй	ЗГ-ын 2026.04.15-ны 127 тогтоолоор улсын төсвийн зардлаар мэдээллийн систем хөгжүүлэхгүй байх чиглэл гарснаар удирдлагаас ажлыг түдгэлзүүлсэн.
15	6.2	0	Үнэлэх боломжгүй	Мөн 127 тогтоолын улмаас сургалтын нэгдсэн системийн хөгжүүлэлт зогссон.
16	6.3	90	90	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хийсэн уулзалтаар Төрийн өмчит хуулийн этгээдийн бүртгэлийн нэгдсэн системд хүний нөөцийн хяналтын модулийг нэмж хөгжүүлэх чиглэл өгсөн. Хөгжүүлэлт хэвийн явцтай, 2026 онд туршиж нэвтрүүлэхээр ажиллаж байна.
Зорилт 7. Төрийн албаны сургалтын чанарыг дааашлүүлэх				
17	7.1	90	90	Ахлах, эрхэлсэн, тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх 3 багц сургалтын агуулга, хөтөлбөрийн шинэчилсэн төслийг ТАЗ, Удирдлагын академитай хамтран боловсруулж, албажуулахад бэлэн болгосон. Жилийн зорилтот 3 хөтөлбөр — батлагдаагүй ч бэлэн.
18	7.2	90	80	БНХАУ, БНЭУ, БНСУ, Канад, Япон зэрэг 5 орны байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэн 5 байгууллагын 13 албан хаагчийг гадаадын богино хугацааны сургалтад хамруулсан. Жилийн зорилтот 40 сургалтын 50% болох 20-аас 13 нь бага тул 80% үнэлэв.
Зорилт 8. Төрийн албаны эрх зүйн орчин, хүний нөөцийн болон төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн асуудал, ЗГ-аас томилж, чөлөөлөх албан тушаалтны томилгооны шийдвэрийн төслийг боловсруулан, ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлэх				
19	8.1	100	100	Төрийн хүний нөөцийн асуудлаар Шийдвэрийн тоо: зорилтот 10, гүйцэтгэл 10-аас их.
20	8.2	100	100	Томилгооны асуудлаар ЗГ-ын тогтоол 23, тэмдэглэл 8, ЕС-ын захирамж 30, нийт 61 баримт бичгийг бэлтгэн батлуулсан. МҮОНРТ-ийн Үндэсний Зөвлөлийн гишүүн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.
21	8.3	100	100	Нийт 56 албан тушаалтны Төрийн ордонд нэвтрэх үнэмлэхний шинээр олголт, сунгалтыг хийж бүртгэн, албажуулсан. Жилийн зорилтот 50-ийн 50% болох 25-аас 56 нь их — 100% биелэлт.
Зорилт 9. Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ЗГ-ын байгууллагуудын хүрээнд зохион байгуулж, удирдлага зохицуулалтаар хангах				
22	9.1	100	100	Мөнгөн урамшууллын журмыг 210-р тогтоолоор батлуулсан. 119-р тогтоолыг хэрэгжүүлж яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ-т хүргүүлсэн. Сахилгын шийтгэлийн журмын зөвшөөрлийг 2026.06.17-д батлуулсан.

				Нийтлэг чиг үүргийн жишиг бүтцийг ЗГ-ын тэмдэглэлээр тогтоосон. Нийт 49 асуудлыг ЗГ хуралдаанаар хэлэлцүүлсэн.
23	9.2	80	70	Ёс зүйн дэд хорооны 2025 оны нэгдсэн тайланг боловсруулсан. 48 гомдол, мэдээллийг холбогдох байгуулагад хүргүүлсэн. Канад-Монголын Мерит төслийн сургалтад 91 байгуулагын 210 төлөөллийн хамт оролцсон. Хагас жилийн зорилтот 3 сургалтын оронд 1 нь хийгдсэн бөгөөд зорилтот түвшинд хүрч чадаагүй тул 70% үнэлэв.
24	9.3	80	80	Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын цахим системд 2025 оны мэдээллийг хуулийн хугацаанд бүртгэсэн. 48 гомдол, мэдээллийг хянаж хүргүүлсэн..
25	9.4	100	100	Тэргүүн түшмэлийн зэрэг дэвийн материалыг буцааж дахин боловсруулсан. 55 албан хаагчид тэргүүн түшмэлийн зэрэг дэв олгуулах санал Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүлсэн. 166 албан хаагчид эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгох Ерөнхий сайдын 118-р захирамж гаргуулсан.
26	9.5	60	60	ТАЗ-ын 44-р тушаалаар дэд ажлын хэсэгт ажилласан. 2026.03.19-ний өдрийн ХЭГ/1704 тоотой тайланг хүргүүлсэн. Хагас жилийн зорилтот 2 арга хэмжээний оронд 1 хэлэлцүүлэгт оролцсон тул 60% үнэлэв.
27	9.6	60	60	Мерит төслийн 1 арга хэмжээний санхүүжилтийн хүсэлт татгалзсан хариу авсан. Мерит төслийн Эмэгтэйчүүдийн манлайллын хэлэлцүүлэгт оролцсон. НҮБ-ын Төрийн албаны чуулганд оролцох бэлтгэлийг хангасан. Хагас жилийн зорилт (2 арга хэмжээ зохион байгуулах)-аас доогуур биелэлттэй.
28	9.7	100	100	ЗГ-аас томилогдох 5 төрлийн ХАСХОМ тайланг 2026.02.26-нд АТГ-т хүргүүлсэн. 63 иргэний ХАСУМ, 153 албан тушаалтны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргуулан авсан. Жагсаалтыг АТГ-т хуулийн хугацаанд 2026.01.12 хүргүүлсэн.
Зорилт 10. Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх ажлын шийдвэр гаргалтад бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх				
29	10.1	90	90	72 чиг үүргийг яамнаас шилжүүлэх санал, 35 чиг үүргийг агентлагаас шилжүүлэх санал, 2022-2025 оны шилжүүлэлтийн мэдээллийн дүн шинжилгээг 2 сард танилцуулсан.
30	10.2	80	80	ЗГ-ын 2026.05.13-ны хуралдааны 25-р тэмдэглэлийн 3 дахь заалтаар чиг үүрэг шилжүүлэх санал ирүүлэхийг холбогдох

				сайд нарт даалгасан шийдвэр гаргуулсан.
Зорилт 11. ЗГ-ын тогтоол, ЕС-ын захирамж, сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүдийг уялдаа, удирдлага зохицуулалтаар хангаж, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх				
31	11.1	100	100	ЗГХЭГ-ын удирдлагын шийдвэрээр байгуулагдсан 8 ажлын хэсэг, бусад байгууллагын 4 ажлын хэсэгт ажиллав. 51-р тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг (Төрийн албаны хуулийн шинэчлэл), 378 тушаалын 4 дэд ажлын хэсэгт нэгдсэн удирдлага хангаж байна. "Зөвлөлдөж шийдье"-ийн 6 хуралдаанд оролцож, 250 хуудас баримтыг архивлав. ЗГ-ын хуралдааны журмын ХШҮ-ний ажлын хэсэгт ажиллав.
Зорилт 12. МУ-ын Ерөнхийлөгч нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдээр төрийн дээд цол, одон, медалиар шагнах асуудлыг судалж шийдвэрлэх, шагнал гардуулах ёслолын ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх				
32	12.1	100	100	Нийт 1396 иргэний (13,079 хуудас) материалыг хянаж Ерөнхийлөгчийн тамгын газарт уламжилсан. Жилийн зорилтот 1000+-ийн 50% болох 500-аас 1396 нь их.
33	12.2	100	100	"Засгийн газрын Хүндэт өргөмжлөл" шагналд нэр дэвшигчийн материалыг яамдаас авч хянан, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Жилийн зорилтот 20+-ийн 50% болох 10+-аас дэлгэрэнгүй явц хэвийн.
Зорилт 13. Байгууллага, нэгжүүд, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, "Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн цахим систем"-д оруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах				
34	13.1	100	100	ЗГХЭГ-т цахим системийн нэвтрүүлэлт 100%, ЗГХЭГ-ын 11 нэгж, 119 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө цахим системаар 100% батлуулсан..
Зорилт 14. Иргэн, хуулийн этгээд, төрийн бусад байгууллагаас ЕС, ЗГХЭГ-ын удирдлагад хандаж ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, хуульд заасан хугацаанд хариу өгч, шийдвэрлэх				
35	14.1	100	100	336 албан бичиг, 80 өргөдөл, гомдлыг хүлээн авч хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь шийдвэрлэсэн. 188 явуулсан албан бичгийг холбогдох байгуулагад хүргүүлсэн.
Нийт дундаж үнэлгээ		88.3%	87.1%	Газрын өөрийн үнэлгээтэй харьцуулахад ялгаатай зорилтууд: Зорилт 1 (60%), Зорилт 2 (50%), Зорилт 4.4 (40%), Зорилт 4.5 (40%), Зорилт 7.2 (80%), Зорилт 9.2 (70%), Зорилт 9.5 (60%), Зорилт 9.6 (60%), Зорилт 10.2 (80%). Зорилт 6.1, 6.2 — ЗГ-ын 127 тогтоолын улмаас үнэлэх боломжгүй.